



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 1/82

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Арвайхээр сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын холболтын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх

Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүд: Б.Мөнхбат -аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө

оруулал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

Б.Ганбат -аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
зөвлөх

А.Оюунчимэг -Орон нутгийн сургалт, судалгааны хөгжлийн
агентлаг ТББ-ын удирдах зөвлөлийн дарга (зөвшилцөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100292